

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Тулга сувилал ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Т.Эрдэнэтуяа

Утас: 89275858

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бүрхэлтэйн гудамж 1, 14 дугаар бэл, Дархан-оул
Дархан-Уул аймаг 45000
Утас: 7037-0080, Факс: (976) 7037-0080
Цахим хуудал: darhanoul@audit.gov.mn
Цахим хуудал: www.audit.gov.mn

2024.12.15 № 116

Талаа _____ хэмээн _____

ШАРЫН ГОЛ СУМЫН "ТУЛГА
СУВИЛАЛ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
А.ИДЭРЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шарын гол сумын "Тулга сувилал" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шарын гол сумын "Тулга сувилал" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдах байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өөрийн хөрөнгөөр эмчилгээний 2ш массажны сандал /3D,4D/ 6,600.0 мянган төгрөг, 2,788.0 мянган төгрөгийн босоо хөргөгч, 468.0 мянган төгрөгийн дээжийн хөргөгч, 508.0 төгрөгийн 12 нүдтэй шүүгээ, 439.0 мянган төгрөгийн багтгэлийн ширээ, 1,199.9 мянган төгрөгийн плиткa, 146.9 мянган төгрөгийн будаа алшаагч, 1,100.0 мянган төгрөгийн суурин даралтын аппарат, 799.9 мянган төгрөгийн ус буцалгагч, 2,500.0 мянган төгрөгийн архивын нягтаршуулсан шүүгээ, 3,422.0 мянган төгрөгийн оффис ширээ сандал худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Тус сувиллын газар нь Мэргэжлээс шалтгаалах өвчний учир хөдөлмөрийн чадвараа алдсан сувилуулагчдыг тав тухтай орчинд хэвтүүлэн сувилгах, сувиллын стандартад заагдсан эмчилгээг гүйцэтгэж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын албан тушаалын цагингийн хэмжээ, доод

хэмжээг шинэчлэн тогтоон 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус сувиллын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 56 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 94.6 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн адийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	153,486,601.54	88,959,142.05
1.1.2	Дансны авлага	1,947,022.00	3,964,407.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	34,920,065.30	69,373,887.08
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	190,353,688.84	162,297,436.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	45,694,843.67	49,482,475.39
1.2.2	Биет бус хөрөнгө	0.00	760,041.08
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	45,694,843.67	50,242,516.47
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	236,048,532.51	212,539,952.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	59,000.00	46,862,209.79
2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	59,000.00	46,862,209.79
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	51,910,420.00	51,910,420.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,710,138.26	5,710,138.26
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	178,368,974.25	108,057,184.55
2.3.11	Эздийн өмчийн дүн	235,989,532.51	165,677,742.81
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	236,048,532.51	212,539,952.60

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	359,844,800.00	411,226,000.00
2	Борлуулалтын өртөг	359,844,800.00	411,226,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	359,844,800.00	411,226,000.00
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	293,017,385.87	481,537,789.70
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	66,827,414.13	(70,311,789.70)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	66,827,414.13	(70,311,789.70)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	66,827,414.13	(70,311,789.70)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	66,827,414.13	(70,311,789.70)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	51,910,420.00	5,710,138.26	-	111,541,560.12	169,162,118.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	51,910,420.00	5,710,138.26	-	111,541,560.12	169,162,118.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				66,827,414.13	66,827,414.13
2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	51,910,420.00	5,710,138.26	-	178,368,974.25	235,989,532.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	51,910,420.00	5,710,138.26	-	178,368,974.25	235,989,532.51
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(70,311,789.70)	(70,311,789.70)
Өмчид гарсан өөрчлөлт			-		-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	51,910,420.00	5,710,138.26	-	108,057,184.55	165,677,742.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	476,720,100.00	411,458,482.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	349,320,000.00	411,458,482.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	127,400,100.00	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	299,706,048.69	453,166,161.49
	Ажиллагчдад төлсөн	166,709,334.26	193,949,141.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,501,071.43	75,095,268.56
	Бараа материал худалдан авахад төлсөн	90,193,161.00	142,042,052.20
	Ашиглалтын зардалд төлсөн	21,302,482.00	42,079,699.73
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	177,014,051.31	(41,707,679.49)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(24,208,400.00)	(22,821,780.00)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(22,821,780.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>152,805,651.31</u>	<u>(64,529,459.49)</u>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	682,950.23	153,488,601.54
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	153,488,601.54	88,959,142.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	359,844,800.00	411,226,000.00	411,226,000.00	51,381,200.00	100.00%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	359,844,800.00	411,226,000.00	411,226,000.00	51,381,200.00	100.00%
3	Нийт зардал	м/төг	293,017,385.87	481,537,789.70	481,537,789.70	188,520,403.83	100.00%
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	293,017,385.87	481,537,789.70	481,537,789.70	188,520,403.83	100.00%
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг			70311789,70		
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	66,827,414.13		(70,311,789.70)		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 484,728.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 481,537.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,382.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 807.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

- Тайлант хугацааны түрээсийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн 481,537.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого болгон залруулав.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тус газрын уламжлалтын болон сэргээн заслын их эмчийн үндсэн цалинг ТҮЭМ-7 зэрэглэлээр цалинжуулснаас нийт 505.9 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “*Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох*”, Засгийн газрын 2023 оны 240 тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын 4-т

“Уламжлалтын болон сэргээн заслын их эмчийг ТҮЭМ-6 зэрэглэлд хамруулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.1.2 Илрүүлэлт: Тус сувилал нь нэг сувилуулагчид ноогдох өдрийн хоолны махны нормыг 1,877,0 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 20.7-д “Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах”, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмжийн хэмжээ батлах тухай” А/74 дүгээр тушаалаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-нд заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

- Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Нийт худалдан авалтыг анхан шатны баримттай тулган шалгахад худалдан авалтын болон и баримтын анхан шатны баримт 807.9 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын төлбөр тооцооны гүйлгээг и баримтад үндэслэн хийж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацааны түрээсийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн 481,537.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого болгон залруулав.	1	481,537.8	-	-	1	481,537.8	1	481,537.8	-	-	-	-
Дүн	1	481,537.8	-	-	1	481,537.8	1	481,537.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус газрын уламжлалтын болон сэргээн заслын их эмчийн үндсэн цалинг ТҮЭМ-7 зэрэглэлээр цалинжуулснаас нийт 505.9 мянган төгрөг илүү олгосон байна.	1	505.9	1	505.9	-	-	-	-	-	-	-	-

Тус сувилал нь нэг сувилуулагчид ноогдох өдрийн хоолны махны нормыг 1,877,0 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	1,877.0	1	1,877.0								
Нийт худалдан авалтыг анхан шатны баримттай тулган шалгахад худалдан авалтын болон и баримтын анхан шатны баримт 807.9 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	807.9					1	807.9				
Дүн	3	3,190.8	2	2,382.9	-	-	1	807.9	-	-	-	-

